

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Мэдээллийн аюулгүй байдал нь нийгмийн олон эрх ашгийг тэнцвэржүүлэн зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг хангах чухал хүчин зүйл мөн. Орчин үеийн тооцоолох техник, мэдээлэл холбооны технологи, хэрэгслүүд амьдралд нэвтэрч, мэдээллийн нийгэмд шилжиж, цахим хэрэглээ нэвтэрснээр хулгай, залилан, тагнуул, далайлган сүрдүүлэх, хорлон сүйтгэх гэмт хэргүүд шинэ хэлбэрт оржээ. Ингэснээр мэдээллийн хүртээмж, бүрэн бүтэн байдлыг хангах, мэдээллийг нууцлах, хамгаалах асуудлыг хуульчлан зохицуулах, монгол улсын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах хэрэгцээ шаардлага тулгараад байна. Дээрх гэмт үзэгдлийг таслан зогсоохын тулд аливаа байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг бий болгох, бодлого, хөтөлбөр, дэг, програм техникийн зохих арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай болоод байна. Үүнтэй холбогдон Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль батлан гаргах эрх зүйн болон практик шаардлага урган гарч ирж байна. Орчин үед мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь зөвхөн програм техникийн арга хэмжээ, мэдээллийг нууцлах асуудал биш эрх зүй, захиргаа удирдлага, дэг журам, програм техникийн цогц арга хэмжээ болон хувирчээ. Энэ шаардлагыг тусгасан хууль батлагдаж байж Монгол улсад Мэдээллийн аюулгүй байдлыг хангаж чадна.

1.1. Эрх зүйн шаардлага

“Монгол улсын Мэдээлэл холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”, “Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Цахим Монгол хөтөлбөр”, “Цахим засгийн мастер төлөвлөгөө”, түүнтэй холбогдуулан гаргасан олон хөтөлбөрүүд болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд мэдээллийн технологийн хөгжлийг эрчимжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим хэрэглээг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар тодорхой заалтууд туссан юм.

Гэвч мэдээллийн хүртээмж, хангамж, нэгдмэл бүрэн бүтэн байдал, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, тогтолцоог зохицуулсан эрх зүйн ямар нэг акт байхгүй, зөвхөн мэдээллийг нууцлах асуудлыг зохицуулсан хуулиуд л үйлчилж

байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан үндэсний аюулгүй байдлыг хангах, иргэний эрх эрх чөлөөг бүрэн хэрэгжүүлэх, шинжлэх ухаан технологийн дэвшил, оюуны өмчийг хамгаалах сонирхлыг хөхүүлэн дэмжихэд чиглэсэн мэдээллийн хэвийн харилцааг бүрдүүлэн, мэдээлэл холбооны технологитой уялдуулах, мэдээллийн нийгмийг цогцлон байгуулах, мэдээлэл холбооны технологийн дэд бүтцийг хамгаалах шаардлагатай нийцэхгүй байна.

Монгол улсад нэгэнт үүсэн бий болж, хэрэгжсэн банкны электрон шилжүүлэг, цахим картын үйлчилгээ, онлайн банк, интернетээр байгуулдаг худалдааны гэрээ, онлайн дэлгүүрийн худалдаа, төрийн цахим үйлчилгээ, цахим баримт бичгийн солилцоо гэх мэт нийгмийн олон харилцааг зохицуулах, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт байхгүй, зоргонд нь хаяснаас нууц мэдээлэл алдагдах, мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэгдэх, сүлжээний үйл ажиллагаа унах, ажиллагаагүй болох, халдлага, довтолгоонд өртөх, веб сайт нь ажиллагаагүй болох, веб сайт болон сүлжээгээр дамжин өгөгдөл мэдээлэлд хандах, ажилтнууд нь мэдээллийг гадагш гаргах, худалдах, сүлжээгээр дамжуулан иргэдийг залилан мэхлэх, өмч хөрөнгө идэж ашиглах, санхүүгийн алдагдалд оруулах, компьютерийн ажиллагааг алдагдуулах гэх мэт элдэв гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, будлиан, учрал жил ирэх тусам нэмэгдсээр байна. Мөн олон түмний, тэр дундаа удирдах ажилтнуудын мэдлэгийн түвшин дээшлэхгүй, мэдээллийн аюулгүй байдлыг зөвхөн програм техникийн арга хэмжээний хүрээнд ойлгож байгаа нь үндэсний аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг болсон мэдээллийн аюулгүй байдлыг хангахад саад учруулж байна.

Монгол Улсад мэдээллийн аюулгүй байдалд учруулж буй хүчин зүйлсийг тодорхойлоогүй, компьютерийн мэдээллийн эсрэг элдэв гэмт халдлагыг “Эрүүгийн хууль”-ийн гуравхан заалтаар зохицуулж байгаа нь үнэхээр хангалтгүй байна.

Монгол улсын хуулиудад байгаа мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой зохицуулалт нь ерөнхий шинжтэй, хомс учраас мэдээллийн аюулгүй байдал, компьютерийн мэдээллийн эсрэг гэмт халдлагуудыг зохицуулах боломжгүй, зарим талаар хэрэгжих үндэслэлгүй байгаа болно.

Монгол улсын Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн өнөөгийн хурдац, мэдээллийн харилцаанд учирч буй элдэв гэмт халдлагын улмаас бүх нийтийг тэгш эрхтэйгээр мэдээлэл, холбооны технологийн үйлчилгээнд хамруулж, мэдээлэлжүүлэх, нээлттэй, цахим засгийг хөгжүүлэх, мэдээллийн үйл ажиллагаанд

оролцогчдын эрхийг хангах, элдэв гэмт халдлага, будлиан учралаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хор хохирлыг нь бууруулах, мөрдөн байцаах, мэдээллийн хүртээмжийг баталгаажуулах, бүрэн бүтэн байдлыг хангах, нууцлах, үүний тулд мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, дэгийг үүсгэж хэрэгжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтыг нэн даруй хуульчлах эрх зүйн шаардлага бий болоод байна.

1.2. Практик шаардлага

Дэлхийн улсуудад улам бүр олширч байгаа мэдээллийн орчин дахь гэмт хэргүүд, гэмт халдлага, будлиан учралын аюул нь мэдээллийн нууцлалыг нэмэгдүүлэх, мэдээллийн хүртээмж, бүрэн бүтэн байдлыг хангах, үүний тулд мэдээллийн аюулгүй байдлын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг бий болголоо. Монгол улсад мэдээллийн нийгмийн цогцлон байгуулж, мэдээлэл, холбооны технологи, цахим хэрэглээ маш хурдтай нэвтэрч, цахим үйлчилгээ өдрөөс өдөрт өргөжин тэлж, иргэн, хуулийн этгээд, төр, засгийн бүх шатны байгууллагыг хамран, тэдний хоорондын мэдээллийн харилцаа улам бүр нарийн төвөгтэй болж байгаатай холбогдон мэдээллийн аюулгүй байдлын будлиан, учрал, гэмт халдлагууд хурдтай өсөн нэмэгдэж байна.

Мэдээллийн аюулгүй байдалд юуг хамааруулан ойлгох талаар хуулийн тодорхой заалт байхгүй байгаа нь мэдээллийн нууцлалыг хангах, мэдээллийг хүртээмжтэй болгох, мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, өөрөөр хэлбэл элдэв гэмт халдлагаас хамгаалах, будлианаас сэргийлэх үйл ажиллагааг явуулах боломжгүй байдалд хүргэж байгаа бөгөөд энэ нь мэдээллийн харилцаанд оролцогчид болон төр, үндэсний эрх ашгийг хохироох, үндэсний аюулгүй байдлыг алдагдуулах сөрөг үр дагавар бий болгож байна.

Гадаадын улс орнуудын туршлагаас харахад мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр нилээд нарийвчилсан хууль эрх зүйн актуудыг боловсруулан мөрдөж байна. Тухайлбал АНУ-ын хуулиудын эмхтгэлд мэдээллийг нууцлах, хүртээмжтэй болгох, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, түүний дотор байгууллага бүрт мэдээллийн аюулгүй байдлын бодлого, хөтөлбөр, дэг бий болгох, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдэд ял шийтгэл оноох, ийм төрлийн гэмт хэргүүдийг мөрдөн байцаах ажиллагааг зохицуулах тухай дэлгэрэнгүй 68 заалт байдаг. Олон улсын болон үндэсний хэмжээнд Компьютер, компьютерийн

мэдээллийг хамгаалах тухай хууль, Компьютерийн гэмт хэргийн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, үзэл баримтлал, Кибер гэмт хэргийн тухай хууль, Мэдээллийг хамгаалах хууль, Хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Мэдээллийн чөлөөт байдлын тухай хууль, Компьютерийн программыг хамгаалах тухай хууль, Мэдээлэл, мэдээлэлжүүлэлт, мэдээллийн хамгаалалтын тухай гэх мэт хуулиуд үйлчилж байна. Япон, Энэтхэг улсад Мэдээллийн технологийн тухай ерөнхий хуулиар мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийг зохицуулсан байдаг. Мөн кибер орчны аюулгүй байдлын талаар бүс нутгийн болон үндэсний хэмжээний хөтөлбөр, захирамж, удирдамжууд батлагдан мөрдөгдөж байна. Байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, бодлого, дэг, хөтөлбөр заавал бий болгосон байх тухай заалт бүхий захирамж, хэм хэмжээт актууд ихэнх улсад батлагдаад байна. Мэдээллийн технологи асар хурдацтай хөгжиж буй өнөө үед өндөр хөгжилтэй дээрх улс орнууд мэдээллийн аюулгүй байдлын салбар хуулиудаа нэгтгэж нэг ерөнхий хууль болгох чиглэлийг барьж байна.

Орчин үед мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд эрх зүйн түвшин, захиргаа удирдлагын түвшин, дэгийн түвшин, програм техникийн түвшинд цогц арга хэмжээ хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Тиймээс Монгол улсын мэдээллийн аюулгүй байдлын хуулинд энэ шаардлагыг бүрэн тусгаж байж мэдээллийн аюулгүй байдлыг хангаж чадна. Дэлхийн улсуудад ийм ерөнхий хууль хараахан батлагдан гараагүй (Солонгосоос бусад) байгаа ч гэсэн Монгол улс энэ чиглэлд анхдагч болж орчин үеийн дээрх шаардлагыг бүрэн тусгасан хууль батлан гаргах нь бусад улсуудад ч үлгэр дууриалтай болно.

1.3 Хуулийн төслийг боловсруулахад тооцон үзсэн бусад асуудал

Процедурын асуудлыг хуульчлахгүй гэдэг шаардлагыг хэт ерөнхийлөх хэмээн ташаа ойлгосны улмаас сүүлийн үед батлагдаж буй Монгол улсын зарим хууль хэт ерөнхийлсөн заалттай, хариуцах эзнийг тодорхой заагаагүй, УИХ-д олонхи болсон улс төрийн хүч засгийн газрын бүтцийг байнга өөрчилдөгийн улмаас байгууллагуудыг нэр заан тодорхойлдоггүй, үүний улмаас эзэнгүйдэх, хариуцлага тооцох боломжгүй болдог буруу практик ажиглагдсаар байна. Тиймээс энэ хуулийн төслийг боловсруулахдаа амьдралд аль болох ойрхон, хэрэгжих үндэслэлтэй, үйлчлэл нь шууд харагдах боломжийг тооцон үзсэн болно. Хариуцах төрийн байгууллагуудыг шууд зааж өгөх нь илүү үр дүнтэй гэж үзсэн. Процедур болон байнга өөрчлөгдөж байдаг технологийн асуудлыг тусгаагүй бөгөөд Мэдээллийн Аюулгүй Байдлын

удирдлага, арга хэмжээ хэрэгжүүлэхэд субъектуудын мөрдөх зан үйлийн дүрмийг тодорхойлоход онцгой анхаарсан болно. Түүнээс гадна хуулийг товч бөгөөд тодорхой заалтуудтай боловсруулсан нь хэрэгжүүлэх, ойлгох, мөрдөх, тайлбарлах магадлалыг өндөрсгөх зорилготой.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Хуулийн төсөл нь 9 бүлэг, 40 зүйлтэй, дараахь ерөнхий бүтэцтэй байна.

2.1.1. Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт хуулийн зорилт, мэдээллийн аюулгүй байдлын харилцаатай холбогдсон хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчим, нууцад хамааруулахыг хориглох мэдээллийн тухай заалтуудыг тусгасан болно. Энэ бүлэгт нууцад хамааруулахыг хориглох мэдээллийг оруулсан нь нууцын тухай монгол улсын хуулиудыг буруугаар тайлбарлаж хэрэглэх, иргэнийн мэдээлэл хүртэх эрх, эрх чөлөө, нийгэм, төрийн мэдээллийн ашиг сонирхлыг зөрчихөөс сэргийлэх зорилготой.

2.1.2 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо

Энэ бүлэгт Монгол улсын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо, УИХ, Ерөнхийлөгч, ЗГ, Мэдээллийн аюулгүй байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын талаар эдлэх бүрэн эрхийн тухай заалтуудыг тусгасан болно. Хэрэв шаардлагатай гэж үзвэл төрийн мэдээллийн аюулгүй байдал эрхэлсэн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн засаг даргын эдлэх бүрэн эрхийг нэмж тусгана.

2.1.3 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага

Энэ бүлэгт төрийн байгууллагууд болон мэдээллийн онц чухал дэд бүтэцтэй (нийгмийн хэвийн амьралыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг) байгууллагуудад заавал хэрэгжүүлсэн байх мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, үзэл баримтлал (стратег), бодлого, хөтөлбөр, эрсдэлийн удирдлага, Мэдээллийн Аюулгүй Байдлын дэг, журмын тухай заалтуудыг тусгасан болно. Төрийн байгууллагууд болон мэдээллийн онц чухал дэд бүтэцтэй байгууллагуудыг Засгийн газраас тогтоох ба бусад байгууллагын хувьд энэ хуулийн заалтуудыг сонгон хэрэглэх боломжтой байхаар тусгасан болно. Төрийн үйлчилгээний зарим байгууллага (ясли, цэцэрлэг гэх мэт), бизнесийн жижиг байгууллагуудын хувьд хуульд заасан бүх арга хэмжээг

хэрэгжүүлэх боломжгүй учир заавал хэрэгжүүлэх байгууллагад оруулах аргагүй. Энэ хуулийн үйлчлэлд заавал хамаарагдах байгууллагуудад Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагууд, хууль хамгаалах байгууллагууд, төрийн тусгай байгууллага, эрчим хүч, ус хангамж, тээвэр, холбоо харилцаа, шуудан, банк гэх мэт онцгой байгууллагууд хамаарагдах юм.

2.1.4 Програм-техникийн арга хэмжээ

Энэ бүлэгт Мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд заавал хэрэгжүүлсэн байх програм-техникийн арга хэмжээ, түүний төрлүүдийг хэрхэн хэрэгжүүлэх тухай заалтуудыг тусгасан болно. Эдгээр заалтуудыг боловсруулахдаа өөрчлөгдөх болох технологийг тухай заалт оруулаагүй, технологи өөрчлөгдсөн ч заавал хэрэгжүүлж байх програм-техникийн арга хэмжээг тусгасан болно.

2.1.5 Туршин баталгаажуулах ажиллагаа

Энэ бүлэгт Төрийн байгууллага, мэдээллийн онц чухал дэд бүтэцтэй байгууллагад ашиглах мэдээлэл боловсруулах, дамжуулах, хадгалах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдлын шаардлага хангаж буй байдал, хортой код суулгасан эсэхийг шалган баталгаажуулж гэрчилгээжүүлэх шаардлага, гүйцэтгэх байгууллага, тусгай зөвшөөрлийн асуудлуудыг тусгасан болно.

2.1.6 Мэдээллийн аюулгүй байдлын аудит

Энэ бүлэгт мэдээллийн аюулгүй байдлыг байнга сайжруулж, үнэлж, орчин үеийн шаардлагад нийцүүлж байхын тулд хэрэгжүүлэх аудит, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, тусгай зөвшөөрлийн тухай заалтуудыг тусгасан болно. Мэдээллийн аюулгүй байдлын аудит нь мэдээллийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй байх ёстой хэрэгсэл, байнга хийгдэж байх ёстой ажиллагаа юм.

2.1.7 Мэдээллийн аюулгүй байдлын будлианы удирдлага

Орчин үеийн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын нэг чухал бүрдэл нь аливаа будлианыг удирдах тогтолцоо билээ. Монгол улс дэлхий дээрх цагаан толбо болсон ба мэдээллийн аюулгүй байдлын ямар ч будлиан, зөрчил, гэмт хэрэг гардаггүй, энэ талын ямар ч статистик байхгүй онцгой улс мэт харагдсаар арваад жил (Интернет орж ирсэнээс хойш) боллоо. Энэ нь манай улсад будлианы удирдлага, түүний эсрэг хариу үйлдэл хийдэг тогтолцоо байхгүйгээс болж байгаа билээ. Мэдээллийн Аюулгүй Байдлын будлианыг илрүүлэх, мэдээлэх, боловсруулах, хариу үйлдэл хийх,

цаашид урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх баг, ажилтан, мэдээлэх, тайлагнах үүргийг энэ бүлэгт тусгасан болно.

2.1.8 Төрийн цахим баримт бичиг, өгөгдөл солилцох дэд системийн аюулгүй байдал

Цахим засгийн үзэл баримтлалаар төрийн бүх байгууллага хоорондоо мэдээллээ цахим хэлбэрээр солилцдог, дамжуулдаг болж цаасгүй технологи жинхэнэ утгаар хэрэгжих ёстой. Энэ ажиллагааг энгийн технологиор, нийтийн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлэхэд аюулгүй байдлын өндөр эрсдэл бий болдог учир цахим баримт бичиг солилцооны системийг заавал байгуулсан байдаг. Энэ бүлэг уг системийн аюулгүй байдлыг хэрхэн хангах үндсэн суурь шаардлагуудыг тусгасан болно.

2.1.9 Үндэсний дата төвийн мэдээллийн аюулгүй байдал

Энэ бүлэгт үндэсний дата төвд хэрэгжүүлэх мэдээллийн аюулгүй байдлын нэмэлт шийдэл, арга хэмжээг тусгасан болно.

2.1.10 Төрийн цахим үйлчилгээний аюулгүй байдал

Цахим засгийн онлайн үйлчилгээ үзүүлэхэд мэдээллийн аюулгүй байдлыг хангах нэмэлт шийдлүүдийг энэ бүлэгт тусгасан болно.

2.1.11. Нөөц хуулбар, сэргээн ажиллуулах төлөвлөгөө

Төрийн өгөгдлийн нөөц хуулбарын төв, үндэсний дата төв дээрх нөөц хуулбарын сервер, онцгой байдлын үед болон түүний дараа системийг сэргээн ажиллуулахд тавигдах шаардлагуудыг тусгасан болно.

Бусад зүйл

Энэ бүлэгт Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нэг суурь нөхцөл болох технологийн хараат байдлыг багасгах, маргаан шийдвэрлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай заалтуудыг тусгасан болно.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал

3.1. Дэлхий нийтийн хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, бодлого, дэгийг хэрэгжүүлэх, аливаа будлиан, учрал,

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, боловсруулах, мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх нь маш чухал асуудал болж байна. Энэ хандлага манай улсын хувьд ч чухал ач холбогдолтой болж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологийн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага бий боллоо. Энэ утгаар юуны өмнө хуулийн төсөлд заасны дагуу бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх, мэдээллийн аюулгүй байдлыг захиргаа удирдлага, дэг, програм техникийн түвшинд хангах цогц арга хэмжээ хэрэгжүүлэх, техник, тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авах, үйлдвэрлэх, хүний нөөцөө бэлдэх, хөгжүүлэх шаардлагатай болох бөгөөд ингэхдээ төсвөөс нэмэлт зардал аль болох гаргалгүйгээр одоогийн байгаа орон тоо, цалингийн фондыг баримжаалан ажиллаж байгаа мэргэжлийн ажилтнуудын хүчийг нэгтгэх, үүсгэн байгуулагдаад ажиллаж буй төрийн бус байгууллага, компанийн бүтэц, зохион байгуулалтыг ашиглах, зарим нарийн мэргэжлийн ажилтнуудыг (мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлын мэргэжилтэн, шинжээч, аудитор, будлиан боловсруулах мэргэжилтэн, сүлжээний мониторинг, лог файлын мэдээллийн шинжилгээ, эмзэг байдлын шинжилгээ хийх чадвартай мэргэжилтэн, сургагч, багш, цагдаа, тагнуулын байгууллагын төлөөлөгч, мөрдөн байцаагч, криминалистикийн шинжээч, тусгай мэргэжлийн шинжээч, зөвлөх г.м) эхлээд цөөн тоогоор гадаад улсад бэлтгэх, улмаар дотооддоо бэлтгэх, дахин мэргэшүүлэх замаар шийдвэрлүүлэх саналтай байна.

Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбогдон гарах зарим шаардлагатай зардал, тухайлбал будлианы эсрэг хариу үйлдэл хийх үндэсний багийг улсын төсвөөс санхүүжүүлж байхаар төсөлд тусгав.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдон төрөөс гарах зардлыг тусгайлан боловсруулж, Засгийн газрын стратеги, бодлого, төслийн хүрээнд жич шийдвэрлэж байх нь зүйтэй гэсэн саналтай байна. Үүнтэй хамт нийгэм-эдийн засгийн үр дагаварын тооцоо, саналыг боловсруулж, үр ашгийг нь тооцож байх нь зүйтэй болов уу.

3.2. Хуулийн төсөлд хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийг Монгол Улсын Засгийн Газар хариуцахаар тусгасан болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуулиудтай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал

Мэдээллийн Аюулгүй байдлын хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон одоо Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа. Хуулийн төсөл батлагдаж, хүчин төгөлдөр болох тохиолдолд үүнтэй холбогдон 43 хуулийн 80 орчим заалтад өөрчлөлт орно. Үүнд:

1.

Жич: Хуулийн төсөл эцэслэн боловсруулагдсаны дараа бусад хуулийн заалтуудад орох өөрчлөлтүүдийг нарийвчлан гаргана.